

НИЙМГИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 11 дүгээр сарын 27

№01

Зүүнбаян-Улаан сум

Энэхүү гэрээг нэг талаас Зүүнбаян-Улаан сумын Засаг дарга Баттөмөр овогтой Баасан (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эм эс бэл майнинг” ХХК-ийн захирал ажилтай Базаррагчаа овогтой Тогооч (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Зүүнбаян-Улаан суманд байгуулсан.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээ нь Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Өртөнт гэх газарт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1 Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1 Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах,

Биелэлт: Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангаж, орон нутгийн удирдлага, иргэдийн зүгээс ямар нэгэн саад учруулаагүй ажилласан байна.

2.1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн, ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах,

Биелэлт: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн, ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах ажлыг цаг алдалгүй ажилласан бөгөөд энэ тал дээр Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр багийн Засаг дарга Найдан идэвхи санаачлагатай оролцсон бөгөөд тус сумаас нийт 5-15 хүн байнгын ажлын байртай ажил үүрэг гүйцэтгэсэн.

2.1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих,

Биелэлт: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд сумын холбогдох албан хаагчид байнга хяналт тавьж ажилласан бөгөөд үйл ажиллагааны явцад аймаг, улсын холбогдох шалгалттай хамт 4 удаа ирж ажилласан байна.

2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах, нөхөн сэргээсэн талбайг хүлээн авах ажлын хэсэг тус уурхайд ажиллах үед сумын орлогч дарга Т.Хүрэлбаатар, холбогдох алба хаагчид ирж ажилласан.

“Эм Эл бэл майнинг” ХХК нь энэ онд техникийн нөхөн сэргээлтийг 8,77 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 2,5 га талбайд хийж гүйцэтгэсэн.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд эвдрэлд өртөн эзэн холбогдогчгүй хаягдаж олон жил болсон Зүүнбаян-Улаан сумын 3 дугаар багийн нутаг Улаан дэл гэх газарт 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж ажилласан.

Мөн өөрийн ашиглалтын талбай доторх олон жилийн өмнө эвдэрч, хаягдсан талбайг тэгшилж техникийн нөхөн сэргээлтийг хийсэн байна.

Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанартай хийсэн, бичиг баримт бүрэн, цэгцтэй, Байгаль орчин хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлт сайн байна гэж ажлын хэсгийнхэн дүгнэсэн байна.

2.1.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх,





Биелэлт: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгч ажилласан байна.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1 Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1 Үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлын талаар зохих журмын дагуу Засаг дарга, ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх,

Биелэлт: Үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлын талаар зохих журмын дагуу Засаг дарга, ИТХ-д тавьж шийдвэрлүүлсэн. Тухайлбал: Хог хаягдлын гэрээ гэх мэт.



Мөн 2024 онд тус компани тусгай зөвшөөрлийн шаардлагатай блок бүхий газар дээр үйл ажиллагаа явуулахаар гэрээ байгуулан ажиллах тул тус сумын 2024 оны газрын төлөвлөгөөнд тусгуулан сумын ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр хүсэлтийг хүргүүлэн ажиллах болно.

3.1.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах,

Биелэлт: Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод нээлттэй хэлбэрээр нийтэд зарлаж 5-15 иргэнийг тогтмол ажлын байртай байлгаж авч ажиллуулсан. Үүнд цалин бусад зардалд 68.000.000 /жаран найман сая/ төгрөг зарцуулсан байна.

3.1.3 Нийт ажлын байрны 30-аас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах,

Биелэлт: Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод нээлттэй хэлбэрээр нийтэд зарлаж 5-15 иргэнийг тогтмол ажлын байртай байлгаж авч ажиллуулсан. Үүнд цалин бусад зардалд 68.000.000 /жаран найман сая/ төгрөг зарцуулсан байна. Харин зарим иргэд самарт явна гэдэг шатгаанаар ажлаа орхин явсан байна.

3.1.4 Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг сумын Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх,

Биелэлт: Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн авч ажиллуулаагүй.

3.1.5 Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох,

Биелэлт: Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгож ирсэн. Тухайлбал: 2 хүн ажилд орохоор анкетаа бүрдүүлж өгөхөд тухайн сумын, багийн иргэдийг тэргүүн ээлжинд авах ажлыг зохион байгуулж ажилласан.

3.1.6 Орон нутгийн малчин иргэдээс 10 үхэр, 1 тооно сүү, цагаан эдээ худалдан авах,

Биелэлт: Тус уурхай ажиллах хугацаандаа орон нутгийн иргэдээс 12 үхэр, 3 адуу, 30 хонь, 1 тонно сүү, цагаан идээг зах зээлийн ханшаар худалдан авсан байна. Худалдан вах үйл ажиллагаанд нийт 45.900.000 /дөчин таван сая есөн зуун мянган/ төгрөг зарцуулсан байна.

3.1.7 Тусгай зөвшөөрөл бүхий 7 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн 5 га газарт биологийн нөхөн сэргээлт хийж, ногоон тэжээл тарьж, тухайн нутаг дэвсгэрт оршин суудаг нутгийн иргэдэд дэмжлэг хэлбэрээр олгох,

Биелэлт: 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах, нөхөн сэргээсэн талбайг хүлээн авах ажлын хэсэг тус уурхайд ажиллах үед сумын орлогч дарга Т.Хүрэлбаатар, холбогдох алба хаагчид ирж ажилласан.

“Эм Эл бэл майнинг” ХХК нь энэ онд техникийн нөхөн сэргээлтийг 8,77 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 2,5 га талбайд хийж гүйцэтгэсэн.

Мөн өөрийн ашиглалтын талбай доторх олон жилийн өмнө эвдэрч, хаягдсан талбайг тэгшилж техникийн нөхөн сэргээлтийг хийсэн байна.



Зураг 16. Нөхөн сэргээлт хийсний дараах ногоон гэжээлийн ургасан байдал



Зураг 18. Ногоон гэжээл хурааж буй байдал

Тухайн биологийн нөхөн сэргээсэн талбайд 1 дүгээр багийн Нарийн жалгын 20 орчим айл ногоон гэжээл хурааж авсан байна.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд эвдрэлд өртөн эзэн холбогдоггүй хаягдаж олон жил болсон Зүүнбаян-Улаан сумын 3 дугаар багийн нутаг Улаан дэл гэх газарт 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж ажилласан.



Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанартай хийсэн, бичиг баримт бүрэн, цэгцтэй, Байгаль орчин хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлт сайн байна гэж ажлын хэсгийнхэн дүгнэсэн байна.

3.1.8 Сум орон нутагт өвөлжилтийн бэлтгэх ажлыг хангах ажлын хүрээнд 700 /таван зуу/-н боодол өвч авч өгөх,

Биелэлт: Сум орон нутагт өвөлжилтийн бэлтгэх ажлыг хангах ажлын хүрээнд 800 /найман зуу/-н боодол өвч авч өгсөн. Үүнд зориулж 15.000.000 /арван таван сая/ төгрөг зарцуулсан.



3.1.9 Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор авто машин авахад 14.000.000 /арван дөрвөн сая/ төгрөг шийдвэрлэж өгөх,

Биелэлт: Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор авто машин авахад 14.000.000 /арван дөрвөн сая/ төгрөг шийдвэрлэж өгсөн.


Лавлах дугаар:	218074684	Гүйлгээний огноо:	2023-11-01
Гүйлгээний төрөл:	БАНК ХООРОНД	Системийн огноо:	2023-11-01
Шилжүүлэгчийн мэдээлэл	Хүлээн авагчийн мэдээлэл	Гүйлгээний дүн	Хайрш
Голомт Банк	Төрийн сан	MNT 14,000,000.00	
6005129090	100100951404	Гүйлгээний утга	0.0
		EmEs bel mainlog hbk Nlgnin hariutslaga	
Шилжүүлэгчийн нэр	Хүлээн авагчийн нэр	Гүйлгээний төлөв	
ЭМ ЭС БЭЛ	ӨВ.ЗБ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ САН	АМЖИЛТГАЙ	

3.1.10 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах,

№	Тайлагнах хэлбэр	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Хугацааны тов	Биелэлт
1	Танилцуулга, уулзалт, санал асуулга	Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Орон нутгийн удирдлага, ИТХ, БОУБ, багаль хамгаалагч	2023 онд	Тухай бүрт нь оролцуулж байгаа
2	Тайлангийн эх хувь, албан бичиг	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	11-р сард	БОМТ-ний биелэлтийн тайланг БОАЖЯ-ны ХБОБНУГ-т хүлээлгэн өгсөн.
3	Төлөвлөгөө тайлангийн эх хувь, албан бичиг	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	12-р сард	БОМТ-ний биелэлтийн тайлан батлагдсанаас хойш 2024 оны БОМТ-ний тайланг 12 сарын 1-ний өдрийн дотор БОАЖЯ-ны ХБОБНУГ-т хүлээлгэн өгнө.

3.1.11 Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, хэрэгсэл, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх,


Биелэлт: Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, хэрэгсэл, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх гэсэн заалтын хүрээнд Зүүнбаян-Улаан сумын төвийн урд хэсэгт байрлах онгийн голын гүүрийг засварласан. Уг засварын ажилд 10.000.000 /арван сая/ төгрөгийн засвар орсон.



Зураг 39.

Гүүр ягзгах үеийн зураг

Мөн сумын төвийн урд хэсэгт байрлах Өлийн даваа, зарим зам харгуйг өөрсвийн хөрөнгөөр янзалж, тэгшлэж өгсөн. Энэ ажилд 10.000.000 /арван сая/ төгрөг зарцуулсан.



Тус уурай нь ниймгийн хариуцлагынхаа хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа багийн үйл ажиллагааг дэмжих, иргэдэд зориулсан үйл ажиллагааг ивээн тэтгэхэд зориулж 4.500.000 /дөрвөн сая таван зуун мянган/ төгрөг, 6 дугаар сарын 01-ны өдөр тухайн багийн хүүхдүүдэд 2.000.000 /хоёр сая/ төгрөгөөр бэлэг авч өгсөн байна.



Зураг 42.

6/1-нд нутгийн иргэдийн хүүхдүүдэд бэлэг тараасан зураг


Тус уурхайн нь 2023 онд ниймгийн хариуцлагын хүрээнд зарцуулсан нийт хөрөнгийг харуулбал:


Хийгдсэн ажил	Зарцуулсан хөрөнгө /мян.тог/
Зүүнбаян-Улаан сумын гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажилд шаардлагатай автомашин шийдвэрлэхэд	14000.0
Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс болж эвдэрсэн Зүүнбаян-Улаан сумын урд байрлах Онгийн голын гүүрийг засварлахад	10000.0
Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлаж 5-15 иргэнийг авч ажиллуулсан.	68000.0
Орон нутгийн малчин иргэдээс 12 үхэр, 3 адуу, 30 хонь, 1 тооно сүү, цагаан эдээ худалдан авсан.	45900.0
Сум орон нутагт өвөлжилтийн бэлтгэх ажлыг хангах ажлын хүрээнд 800 /найман зуу/-н боодол өвч авч өгөх,	15000.0
6 дугаар сарын 1-нд нутгийн иргэдийн 0-16 насны 80 хүүхэдэд бэлэг авч өгсөн.	2000.0
Тухайн багийн үйл ажиллагааг дэмжих, иргэдэд зориулсан үйл ажиллагааг ивээн тэтгэхэд зориулж	4500.0
Зүүнбаян-Улаан сумын урд байрлах ширүүн өлийн давааг янзлахад	10000.0
Нийт	176000.0

Гэрээний биелэлт: 2023 онд тус уурхай нь 8 багц асуудлаар нийт 176.000.000 /нэг зуун далан зургаан сая/ төгрөг нийгмийн хариуцлагын хүрээнд заруулсан бөгөөд сумтай байгуулсан "Нийгмийн хариуцлагын гэрээ"-г 100 хувь хангасан гэж үзэж байна.

Шийдвэр:

Гэрээг дүгнэсэн:

ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН
ЗАСАГ ДАРГА  Б.БААСАН

"ЭМ ЭС БЭЛ МАЙНИНГ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ  Б.ТОГООЧ

